

## **ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ**

*Д.Гангабаатар (Ph.D)*  
*Нийтийн эрх зүйн тэнхим*  
*ХЗС. МУИС*

**Түлхүүр угс:** Үндсэн хууль, төр, сүм хийдийн харилцааны үндсэн зарчим, шашин

**Төвч утга:** Энэхүү илтгэлд төр, сүм хийдийн харилцаанд баримтлах Үндсэн хуулийн зарчмын талаар хөндөх болно.

\* \* \* \* \*

Төр сүм хийдийн харилцаа, ялангуяа бүртгэлийн асуудлаар өөр илтгэл тавигдах тул миний бие энэ илтгэлээрээ Үндсэн хуулийн зохицуулалт талаас нь голчлон хөндөх болно. Монгол Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд: Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ; Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй; Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна гэж заасан.

Төр сүм хийдийн харилцаанд баримтлах эдгээр зарчим нь Үндсэн хуулийн 16.15-т тусгасан шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй шууд холбоотой. Үндсэн хуулийн зарчим, үзэл баримтлал эдгээр зохицуулалтад оршиж байна. Нэгдүгээрт, Үндсэн хуулийн 9.1-р зүйлийн зохицуулалт нь төр сүм хийд харилцан хүндэтгэлтэйгээр хамтарч ажиллана гэсэн агуулгатай байна. Төр нь шашнаа хүндэтгэж, харин шашин нь төрийн хуулийг биелүүлнэ. 9.2-р зүйлд хамтарч ажиллахын хажуугаар тодорхой зааг, хүрээнд салангид бие даасан орших үндсийг бүрдүүлжээ. 9.3-т төр, сүм хийдийн харилцааг дээрх зарчмуудын хүрээнд хуулиар зохицуулах боломжийг парламентад нээлттэй үлдээсэн байна. Хууль тогтоогч төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулахдаа гагцхүү Үндсэн хуульд заасан зарчимд нийцүүлэн зохицуулах үүрэг хүлээжээ.

Дээр дурдсан төр сүм хийдийн харилцаанд баримтлах Үндсэн хуулийн хоёр зарчим нь хамтарч ажиллах болон харьцангуй бие даасан байхыг даалгасан байна. Энэ хоёр зохицуулалтын агуулгыг тодорхойлох шаардлагатай. Нэгдүгээр зарчим буюу хамтарч ажиллах зарчим нь төр, сүм хийдийн харилцаа бүрэн тусгаар, салангид байх онолыг үгүйсгэж байна. Энэ онолоор төр сүм хийд бүрэн тусгаар байснаар шашин шүтэх эрх чөлөө хангагдана. Эс бөгөөс зөрчигдөхөд хүрнэ гэж үздэг.

Гэвч огт харилцаа холбоогүй, ангид байх нь эргээд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах нөхцөл бүрдүүлнэ. Ус, цахилгаан, халаалт, галын аюул, гэмт халдлагаас хамгаалах гээд төрийн үйлчилгээ, хамгаалалтгүйгээр сүм, хийд үйл ажиллагаагаа явуулах боломжгүй. Шашин шүтэх эрх чөлөө зөрчигдөхөд хүрнэ. Төрөөс шашны байгууллагад үйлчилгээ үзүүлэх нь гарцаагүй. Олон шашин, урсгалууд хоорондоо эв найртай хамтарч оршихын тулд төрийн зүгээс тодорхой хуулийн зохицуулалт хийх шаардлагатай. Харин ямар хүрээнд хамтарч ажиллах вэ?

Энэхүү хамтын ажиллагаа нь улс бүрд өөр байна. Үндсэндээ төр, сүм хийдийн харилцааг хоёр ангилж үзэж болно. Эхнийх нь төрийн шашинтай, шашин төр холилдсон улс байна. Мусульман шашинтай олон улс, мөн зарим нэг буддын болон христын

шашинтай улс үүнд багтана. Исламын шашныг төрийн шашин гэдэг Сауди Араб, Иран, Оман, Ирак, Египет, Малайз гээд олон улс байна. Христын шашныг төрийн шашин гэж үздэг эсхүл төрийн сүмтэй улс Аргентин, Дэнмарк, Их Британи, Грек, Коста Рика гээд цөөнгүй улсууд байна. Буддизмийг төрийн шашнаар тогтоосон Бутан, Камбож, Лаос, Мьянмар, Шриланк, Тайланд гээд улсууд байна. Бутан болон Камбожид төрийн шашин гэж үздэг бол бусад дурдсан улсуудад Буддын шашинд тусгай статус Үндсэн хуулиараа олгосон байна.

Дараагийн ангилалд шашин төр тусгаар орших улсууд байна. АНУ ийм улсын жишээ болно. Энэ хоёр туйлын үзлийн дунд орших ихэнх улсууд соёл, уламжлалын шалтгаанаар уламжлалт шашнаа дэмжих хандлагатай байгаа нь ажиглагддаг. Зарим улсад төрөөс шашны сургуульд дэмжлэг үзүүлэхийг дэмждэг бол, зарим нь үгүйсгэж байна. Дэмжлэг үзүүлбэл хэт оролцлоо, үзүүлэхгүй бол алагчлан үзлээ гэх. Гэвч олон улсад нийтлэг байгаа нэг хандлага бол уламжлал, соёлын нэгээхэн хэсэг болж төлөвшөн түүхэн уламжлалт шашнаа дэмжих хандлага юм. Энэ нь нэг шашныг нөгөөгөөс илүүд үзэх хандлагаар бус харин соёлоо хамгаалах, уламжиллаа өвлөх зэргээс гадна аялал жуулчлал, эдийн засгийн ач холбогдолтой байдагтай холбоотой.

Монгол Улсын хувьд аль ангилалд хамаарах вэ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ гэсэн хуулийн заалт Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэхдээ яг ийм үндэслэл дэвшүүлсэн. Буддын шашин бол уламжлалт шашин. Уламжлал, соёлд нэвт шингэсэн. Түүхэн дурсгал, соёлын өв, уламжлалт үнэт зүйлс гэдэг талаас нь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэх нь Үндсэн хуулийн үзэл баримтлал гэж Цэц тайлбарласан. Цэцийн дүгнэлт чухал үр нөлөөтэй. Учир нь цэцийн дүгнэлт нь Үндсэн хуулийн тухайн зүйл заалтын тайлбар болдог. Үндсэн хуулийн тайлбар нь Үндсэн хуулийн зүйл заалтын дэлгэрүүлсэн агуулга болохын хувьд Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг юм. Үндсэн хуулийн тайлбарыг өөрчлөх хоёр үндсэн арга зам бий. Эхнийх нь УИХ нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эсхул ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуулийн тайлбарыг агуулгыг өөрчлөх боломжтой. Нөгөө арга нь Үндсэн хуулийн цэц өмнө нь гаргасан шийдвэрийн агуулгыг өөрчилсөн шийдвэр гаргах юм.

Хоёрдахь зарчим буюу харилцан бие биесээс хараат бус байх зарчим нь эхний зарчмын хүрээнд хэрэгжинэ. Уламжлалт шашнаа хүндэтгэнэ. Гэхдээ бусад шашны сүсэгт хүмүүсийн шашин шүтэх эрх чөлөөнд халдахгүй байх ёстой гэж Цэц үзсэн. Төрийн зохицуулалт зайлшгүй хэрэгтэй. Ардчилсан нийгмийн үнэт зүйлс, нийгмийн дэг журам, үндэсний аюулгүй байдалд занал учруулах шашны урсгалаас сэргийлэх учиртай. Ийм хуулийн зохицуулалт хэрэгтэй. Ямар шашны байгууллага, хаанаас ямар зохион байгуулалттайгаар орж ирээд ямар үйл ажиллагаа явуулж байгааг төр нь мэдэх үүрэгтэй. Бүртгэдэг байх хэрэгтэй.

Дэлхийд өrnөж буй олон дайн, зэвсэгт мөргөлдөөн, энгийн иргэдийн амсаж буй зовлон зүдгүүр шашинтай холбоотой байх нь олон байна. Ойрх дорнодыг хар. Шашны байгууллагын хуваагдал, талцлыг гаднын дайснууд нь ашиглаж улс орныг мөхөлд хүргэж байгааг Сирийн жишээнээс харж болно. Бүх шашин ёс суртахууныг, хайр энэрлийг номлодог. Харин бурхны хайрын нэрийн өмнөөс буруу номтны хүүхдийн толгойг авдаг, цовдолдог явдал дэлхийн түүхэнд байсан. Одоо ч байсаар байна.

Тиймээс шашнаар дамжуулан үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх, үзэл суртал нэвтрүүлэх гэсэн оролдлогыг таслан зогсоох нь хуулийн үүрэг юм. Иргэдийнхээ шашин

шүтэх эрх чөлөөг хамгаалах үүднээс шашны байгууллагыг бүртгэдэг, хяналт тавьдаг байх шаардлагатай. Бүртгэх журам, тавигдах шаардлагыг тодорхой болгох хэрэгтэй. Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчвөл хариуцлага хүлээх ёстай. Энэ нь шашин нь төрөө дээдлэх зарчмын нэг элемент юм.

Хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, харгис шашин номлол түгээсэн зэрэг хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага хүлээлгэдэг болох хэрэгтэй. Шаардлагатай бол үйл ажиллагаа явуулахыг хориглох хүртэл арга хэмжээ авах нь шашин нь төрөө дээдэлж хуулийн дор оршихын учир юм. Дээрхээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд төр, сүм хийдийн харилщааг зохицуулахдаа шашин шүтэх эрх чөлөөг позитив эрхийн үүднээс хамгаалсан байна. Өөрөөр хэлбэл төрийн зүгээс хуулиар зохицуулах замаар, шашин шүтэх эрх чөлөөгөө өдлэх боломжийг нь бүрдүүлнэ. Үндсэн хуульд тусгагдсан зарчмууд нь төрийн оролцоог үгүйсгээгүй бөгөөд Үндсэн хууль ёсыг дээдлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хамгаалах шаардлагад нийцүүлэн шашны байгууллагатай хамтарч ажиллах орон зайд үлдээсэн байна. Мөн зорилгоор төрийн байгууллага шашны үйл ажиллагаа эрхлэх, шашны байгууллага улс төрийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон байна.

## **НОМ ЗҮЙ**

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль

## **ABSTRACT**

Monastery and state relationship is regulated by the 1993 Law on monastery and state relationship in conformity with the principles enshrined in the Constitution of Mongolia. Constitutional court of Mongolia interpreted and clarified relevant constitutional provisions by its decision on constitutional disputes. Number of amendments were introduced to the law in the past, but non offered significant changes. In order to ensure that the citizens religious freedom, the law needs to change and improve. This paper examines the need to amend the Law on monastery and state relationship within the principles stipulated in the Constitution in order to better protect the religious freedom.